



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/88

Мандалговь

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дүгээр захирамжаар батлагдсан "Урамшууллын жишиг тогтоох журам"-ын 2.1, 2.2 дах заалтууд, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Гавьяат жүжигчин, Зууны манлай, Алдарт уртын дуучин Ж.Дорждагвын нэрэмжит "Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрын язгуур урлагийн багш, Төв Азийн "Халх эмэгтэй туульч" өргөмжлөлт, Луус сумын харьяат Халтарын Цэрэнчимэд Төрийн дээд шагнал "Монгол Улсын Гавьяат жүжигчин" цол хүртсэн тул 500000 /таван зуун мянган/ төгрөгийн, "Говь тэнгэр" ХХК-ийн зөвлөх Лэгцэгийн Санзай "Монгол Улсын Гавьяат эдийн засагч" цол хүртсэн тул 400000 /дөрвөн зуун мянган/ төгрөгийн урамшуулал олгож, тус бүрийг аймгийн Засаг даргын "Хүндэт өргөмжлөл"-өөр шагнасугай.

Хоёр. Мөнгөн шагналд 900000 /есөн зуун мянга/, Хүндэт өргөмжлөл хэвлүүлэхэд 70000 /далан мянга/, нийт 970000 /есөн зуун далан мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Д.Нандинцэцэг/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

9200257